



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Сэлэнгэ аймгийн Аудитын газрын төлөвлөгөө,
удирдамжийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

“СЭЛЭНГЭ БАРИЛГА ЗАХИАЛАГЧ” ОНӨААТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

*“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь орлогоороо зарлагаа нөхөж, өөрөө
өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байна.*

Тайланг бэлтгэсэн: УАГ-ын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газар	Аудитын хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд, 1.”Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу.
Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	<i>1.1.Үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу</i> <i>1.2.Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн тайланг ТУЗ болон холбогдох бусад байгууллагаар хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байна уу.</i> <i>1.3.Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу.</i>
Аудитын менежер Б.Батмөнх	2. “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу.
Ахлах аудитор Б.Наранчимэг	<i>2.1.Үйл ажиллагааны орлогыг бүрэн дүүрэн, үндэслэлтэй төлөвлөн төвлөрүүлж байна уу.</i> <i>2.2.Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу</i> <i>2.3.Авлага, өглөгийг барагдуулж, үр ашигтай ажиллаж байгаа эсэх.</i>
2016 оны 06 сар	3.Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442 дугаарын утас, 70363040 дугаарын факсаар харилцана уу.	<i>3.1.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зохион байгуулж байна уу</i> <i>3.2.Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагын хэмжээнд бэлтгэн, ашиглаж байна уу</i> <i>3.3.Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого, тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж байна уу.</i>
ХАЯГ:Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум аймгийн ЗДТГ-ын байрны Өргөтгөлд	Илрүүлсэн зөрчил Аудитын дүгнэлт Зөвлөмж

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол улс
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
СТСХ	Санхүү Төрийн Сангийн Хэлтэс
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХАА	Худалдан авах ажиллагаа

НЭГ.АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнд аудит хийж дүнг албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд гүйцэтгэлийн аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

1. “Сэлэнгэ барилга захиалагч “ОНӨААТҮГ- ын үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу.
 - 1.1. *Үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу*
 - 1.2. *Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн тайланг ТУЗ болон холбогдох бусад байгууллагаар хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байна уу.*
 - 1.3. *Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу.*
2. “Сэлэнгэ барилга захиалагч “ОНӨААТҮГ нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу.
 - 2.1. *Үйл ажиллагааны орлогыг бүрэн дүүрэн, үндэслэлтэй төлөвлөн төвлөрүүлж байна уу.*
 - 2.2. *Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу*
 - 2.3. *Авлага, өглөгийг барагдуулж, үр ашигтай ажиллаж байгаа эсэх.*
3. Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу.
 - 3.1. *Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зохион байгуулж байна уу*
 - 3.2. *Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагын хэмжээнд бэлтгэн, ашиглаж байна уу*
 - 3.3. *Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого, тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж байна уу.*

Хамарсан хүрээ

Аудитаар тус ОНӨААТҮГ-ын 2015, 2016 оны эхний улирлын байдлаар хэрэгжүүлсэн ажил үйлчилгээ, орлогын бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалтыг хамарч шалгав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж / АДБОУС-3000-3001/-ийн дагуу аудитын тайлангийн дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгаанд тулгуурлан аудитыг хийж гүйцэтгэв.

Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

МУ-ын Төсвийн тухай хууль, Иргэний тухай хууль, Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиуд болон эдгээр хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”, Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм” болон холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Б.Наранчимэг 2016 оны 06 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 28-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

ХОЁР.ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь 2014 оны 02-р сарын 12-нд байгуулагдаж гуравдугаар ангиллын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлэх, гүйцэтгэх явцад захиалагчийн техникийн хяналтыг гүйцэтгэн ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2014 оны 02-р сарын 12-ны өдрийн тогтоолоор тус үйлдвэрийн газрын дүрмийг батлан, даргаар нь Б.Равдандоржийг томилжээ. Тус үйлдвэрийн газар нь 2014 онд 134.4 сая төгрөгийн орлого олж 79.4 сая төгрөгийн зардал гарган ажиллаж 49.5 сая төгрөгийн цэвэр ашигтай, 2015 онд 89.4 сая төгрөгийн орлого олж 106.4 сая төгрөгийн зардал гарган 17.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитад хамрагдсан 2015 онд 26.0 сая төгрөгийн авлага шинээр үүсч 33.3 сая төгрөгийн авлагыг барагдуулжээ. Шинээр 124.6 сая төгрөгийн өглөг үүсч 115.5 сая төгрөгийн өр төлбөрийг төлж барагдуулсан байна.

Тус ОНӨААТҮГ-ын дарга Б.Равдандорж 1-р гарын үсгийг, нягтлан бодлогч Н.Цэндээхүү 2015 оны 09-р сарын 01 хүртэл, мөн өдрөөс өнөөг хүртэл нягтлан бодогч Д.Нандинэрдэнэ 2-р гарын үсгийг тус тус зурж, хөрөнгийг захиран зарцуулж ирсэн байна.

ГУРАВ.АУДИТЫН ДҮН

Бүлэг 1. “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

1.1.”Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийг биелүүлж байгаа боловч үйл ажиллагаа нь зарим талаар холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн байна.

1.1.1. Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2014 оны 02-р сарын 12-ны өдрийн 11 дугаар тогтоолоор “*барилга байгууламж барих засварлах, шинэчлэх, өргөтгөх ажлыг эхлүүлэх, гүйцэтгэх явцад техникийн нөхцөл болон технологийн хяналт тавьж, гүйцэтгэлийг баталгаажуулах, барилга байгууламжийг хугацаанд нь ашиглалтанд оруулах ажлыг сайжруулах*” зорилгоор ЗД-ын дэргэдэх “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ыг 15 хүртэл орон тоотойгоор байгуулж үйлдвэрийн газрын дүрмийг баталсан байна.

1.1.2. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүн нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-гийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэх хөрөнгө оруулалтын хэмжээнээс шууд хамааралтай учир эдгээр төрлийн хөрөнгө оруулалтын ажил ихтэй байсан 2014 онд ашигтай ажиллаж, хөрөнгө оруулалтын хэмжээ харьцангуй буурсан 2015 он болон 2016 оны эхний улирлын байдлаар алдагдалтай ажиллажээ. Үйл ажиллагааны үр дүнг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 / мян төг /

Он	Орлого	Зарлага	Ашиг	Алдагдал
2014	134446.5	79461.2	54985.2	
2015	89406.2	106411.3		17005.1
2016 оны 1-р улирал	1375.4	23422.5		22017.1

Ингэж сүүлийн жилүүдэд үндсэн үйл ажиллагааны орлогоороо зарлагаа нөхөж чадахгүй, алдагдалтай ажиллаж байгаа нь МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15-р зүйлийн 2 дах “**Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ**” гэсэн заалтыг зөрчиж байгаагаас гадна цаашид уг аж ахуйн нэгж оршин тогтнох чадамж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, удирдлага, зохион байгуулалт, менежментийн өөрчлөлт зайлшгүй хийх шаардлагатай болохыг харуулж байна.

1.1.3. 2015 онд улсын болон орон нутгийн төсөв, ОНХС, замын сангийн эх үүсвэрээр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн болон хандив тусламжаар санхүүжүүлсэн нийт 60 төсөл арга хэмжээний техникийн хяналтыг гэрээний дагуу гүйцэтгэж 63.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

д/д	Эх үүсвэр	Ажлын тоо	Нийт санхүүжилт /сая.төг/	ТХЗ /сая.төг/	Дансанд төвлөрсөн /сая.төг/
1	Улсын төсвийн ХО	7	1582.9	16.4	14.5
2	Орон нутгийн төсвийн ХО	11	819.9	16.8	11.2
3	Орон нутгийн хөгжлийн сангийн ХО	29	1343.4	25.1	21.4
4	Замын сангийн ХО	4	352.9	6.2	4.9
5	Хувийн хэвшил, хандив тусламж	9	924.3	12.8	11.2
Нийт		60	5023.4	77.3	63.2

1.1.4. Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ нь техник хяналтын гэрээг захиалагчтай бус төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч компанитай байгуулан, захиалагчийн зүгээс хяналтын зардлыг төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компанид шилжүүлж байгаа нь . Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын 3.19 дэх “Захиалагч барилгын ажлын зардал, ТЭЗҮ, зураг төслийн үнэ, техник хяналтын зардал, нормчлолын сангийн зардлыг **тус тусын дансанд** холбогдох баримт, материалыг үндэслэн шилжүүлнэ” гэсэн заалтыг зөрчихөөс гадна гүйцэтгэгч компаниас техник хяналтын зардлаа авч чадахгүй, улмаар санхүүгийн хувьд гүйцэтгэгчээс хараат байдалд орох нөхцлийг бүрдүүлж, оны эцэст их хэмжээний авлагатай тайлагнагджээ.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3 / сая төг /

Эх үүсвэр	Гэрээний дүн	Тооцсон ТХЗ	Дансанд төвлөрсөн	Гүйцэтгэгчээс авах ТХЗ
1.Улсын төсвийн хөрөнгө оруулалт	1582.9	16.4	14.5	1.9
2.Орон нутгийн хөрөнгө оруулалт	819.9	16.8	11.2	5.6
3.ОНХС	1343.4	25.1	21.4	3.7
Нийт	3746.2	58.3	47.1	11.2

1.1.5. “Сэлэнгэ барилга захиалагч “ОНӨААТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.6¹ - д холбогдох **эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг** авсны үндсэн дээр захиалгаар тодорхой хэмжээний зураг төсөв хийх эрхтэй байж болно гэж заасан байдаг. Гэвч зураг, төсөв хийх зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авч захиалагчтай байгуулсан гэрээний дагуу өөрсдөө зураг төсөв хийх бус “Талхун арал”, “Бурхант орд” ХХК-тай захиалагчийн өмнөөс гэрээ байгуулан гүйцэтгүүлж зураг төсвийн үнийн 80,0 хувь болох 8.0 сая төгрөгийн орлого олсон нь дүрмийн дээрх заалтыг зөрчихөд хүргэж байна. Зураг төсвийн гэрээ хийж орлого бүрдүүлсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

¹ “Холбогдох **эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг** авсны үндсэн дээр захиалгаар тодорхой хэмжээний зураг төсөв хийх эрхтэй байж болно”

Хүснэгт №4 / сая төг /

Төсөл хөтөлбөр	Зураг төсвийн үнэ
1.Мандал сум дах ШШГА-ны 0412-р ангийн Цагдан хорих байрны засвар, өргөтгөлийн барилга угсралтын ажил, хашааны зураг төсөв	1.9
2.Хушаат сумын 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв	3.4
3.Хүдэр сумын багуудын цахилгаан хангамж сайжруулах ажлын зураг төсөв	0.7
4.Хүдэрдулаан ОНӨААТҮГ-ын халаалтын тогооны засвар шинэчлэлийн ажлын зураг төсөв	2.0
Нийт	8.0

1.2. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээг дүгнэснээс өөрөөр тус байгууллагын үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт, цаашид хэрхэн ажиллах талаар чиглэл өгөөгүй байна.

1.2.1. “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын дүрмийн 4 дэх зүйлийн 4.1-д “*Үйлдвэрийн газрын бүтэц, жилийн төсөв, цалингийн дээд хязгаарыг аймгийн Засаг дарга тогтооно*” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2015 оны 03-р сарын 31-ны өдрийн А/104 тоот захирамжаар тус үйлдвэрийн газрын 2015 оны бизнес төлөвлөгөө, төсвийн төлөвлөгөөг баталсан байна.

1.2.2. Харин 2016 оны орлогын болон төсвийн төлөвлөгөөг аймгийн Засаг дарга бус үйлдвэрийн газрын даргын 2016 оны 05-р сарын 03-ны өдрийн А/01 дугаар тушаалаар баталсан нь “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын дүрмийн 4 дэх зүйлийн 4.1-дэх заалтыг зөрчсөн байна.

1.2.3.Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын дарга Б.Равдандорж нь аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээг 3 жилийн хугацаатайгаар 2014 оны 03-р сарын 23-ны өдөр байгуулж 2014 онд 97.7 хувь, 2015 онд 98.6 хувь буюу “**дүүрэн хангалттай**” гэсэн үнэлгээтэй дүгнүүлжээ.

1.2.4. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны тайланг жилийн эцэст ганц удаа л аймгийн ИТХТ болон Засаг даргад тайлагнаж, үр дүнгийн гэрээг дүгнүүлж байгаа нь үйлдвэрийн газрын дүрмийн 4 дэх зүйлийн 4.9-д “*Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны тайланг улирал, хагас бүтэн жилээр гаргаж аймгийн Засаг даргад...тайлагнана*” гэсэн заалттай нийцэхгүй байна. Хэдийгээр үйл ажиллагааны тайланг үйлдвэрийн газрын дүрэмд заасны дагуу улирал, хагас жилээр бус ч гэсэн жилийн эцэст аймгийн ИТХ болон Засаг даргад толилуулж, холбогдох албан тушаалтны зүгээс “**хангалттай**” гэж дүгнэж байгаа боловч техникийн хяналтын гэрээг гүйцэтгэгч компанитай байгуулсан, санхүүжилтээ бүрэн авч чадахгүй их хэмжээний авлага үүсгэсэн, орлогоороо зарлагаа нөхөж чадахгүйгээс цаашид оршин тогтнох нөхцөл алдагдаж байгаа байдалд нь дүгнэлт өгч цаашид хэрхэн ашигтай ажиллах арга замыг тодорхойлоогүй зэргээс гэрээ дүгнэх ажиллагаа бодитой бус болж байна гэж дүгнэж байна.

1.3. Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт огт хийгдээгүй байна.

1.3.1. Аймгийн ИХТТ нь МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2² -д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй, зөвхөн газрын дүрмийг баталснаар хязгаарласан байна.

1.3.2. Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын зүгээс Засаг даргатай байгуулсан гэрээг оны эцэст хийсвэрээр дүгнэснээс өөрөөр үйл ажиллагаанд нь хяналт тавиагүй, цаашид үйлдвэрийн газрын үйл ажиллагааг тогтвортой, үр ашигтай явуулах арга замыг тодорхойлоогүй, санхүүгийн үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийгдээгүй байна.

Бүлэг 2. “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу.

2.1. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөлтийг аймаг, орон нутгийн хөрөнгө оруулалтын хэмжээтэй уялдуулан хийсэн боловч зарим төсөл хөтөлбөр ажлуудыг орхигдуулсан, өөрийн чиг үүрэгт хамааралгүй ажлуудыг оруулан тооцоноос гадна тооцооллын алдаа гаргаж орлогыг өндрөөр төлөвлөсөн байна.

2.1.1. Аймгийн ИТХ-ын 2015 оны 12-р сарын 04-ний өдрийн 72 дугаар тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1042.8 сая төгрөг, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2173.5 сая төгрөг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2436.6 сая төгрөг, замын сангийн хөрөнгөөр 378.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр, 2016 оны 03-р сарын 25-ны өдрийн 80 дугаар тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар 451.5 сая төгрөг, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 3081.3 сая төгрөг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 4483.5 сая төгрөг, замын сангийн хөрөнгөөр 517.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

2.1.2. Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлуудаас 2015 онд нийт 4103.3 сая төгрөгийн ажил, 2016 онд 4505.0 сая төгрөгийн ажлын техникийн хяналтыг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ хэрэгжүүлэх боломжтой гэж тооцож үзэхэд өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй Сэлэнгэ, Орхон бүсийн зам засварын ажлын зураг төсөв зэрэг 5.9 сая төгрөгийн ажлыг хамааруулж орлогыг 6.3 сая төгрөгөөр илүү, 2016 онд Мандал сумын 126 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний ажил, Сант, Орхон сумын наадмын талбай барих, Ерөө сумын хөлбөмбөгийн талбай барих, Алтанбулаг сумын сургуулийн их засвар, Орхон сумын эмнэлгийн засвар зэрэг 17 төрлийн 1224.0 сая төгрөгийн ажлыг орхигдуулж, аймгийн наадмын талбайн усан хангамж, худалдааны төвийн лангуу угсрах, Хүдэр суманд орон нутаг судлах танхимын тоног төхөөрөмж зэрэг хамааралгүй 5 ажлын 200.0 сая төгрөгийн ажлыг оруулан тооцож орлогыг 25.1 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна. / Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 1.2-т үзүүлэв./

² Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж дүгнэлт чиглэл өгөх

2.1.3. 2015 онд үйл ажиллагаанаас 113.2 сая төгрөгийн орлого, 2016 онд /техникийн хяналт тавих ажлын төсөвт өртгийг тооцооллын алдаатай тооцсон / 97.2 сая төгрөг, хувийн хэвшлийн компаниудаас болон өөрийн туслах үйл ажиллагаанаас 30.9 сая төгрөг нийт 128.1 сая төгрөгийн орлого олохоор бизнес төлөвлөгөөнд тусгажээ. Орлогын төлөвлөлтийг аймгийн ИТХ-р батлагдсан төсөл хөтөлбөртэй хэрхэн уялдуулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5

Эх үүсвэр		Аймгийн ИТХ-ын 2015 оны 12.04-ны өдрийн 72-р тогтоол	Аудитаар давтан тооцоолсон	Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-ын тооцоолсон	Аймгийн ИТХ-ын 2016 оны 03.28-ны өдрийн 80-р тогтоол	Аудитаар давтан тооцоолсон	Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-ын тооцоолсон
Орон нутгийн хөрөнгө	Шилжих хөрөнгө оруулалт	71.6		126.1	395.5		
	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	506.1	451.6	451.6	21.0		
	Тоног төхөөрөмж	225.3			35.0		
	Их засвар	162.5	134.6	134.6			
	Хөтөлбөр арга хэмжээ	77.3					
Дүн		1042.8	586.2	712.3	451.5	х	х
Аймгийн ОНХС хөрөнгөөр	Шилжих хөрөнгө оруулалт	1087.8			711.3	412.0	108.0
	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	487.9	487.9	487.9	1508.0	1374.5	819.5
	Тоног төхөөрөмж	112.9			228.5		
	Их засвар	434.9	351.9	351.9	492.5	444.5	244.5
	Хөтөлбөр арга хэмжээ	50.0			141.0		
	Сумын ОНХС хөрөнгөөр	2436.6	2304.3	2304.3	4483.5	1736.4	1736.4
Дүн		4610.1	3144.1	3144.1	7564.8	3967.4	2908.4
Замын сангийн хөрөнгөөр		378.9	373.0	378.9	517.6	537.6	572.1
НИЙТ		6031.8	4103.3	4235.3	8533.9	4505.0	3480.5
Тооцсон орлого		х	106.7	113.0	х	72.1	97.2

2.1.4. Тайлант 2015 онд урьд оны авлагаас 18.9 сая төгрөг, зураг төсөв боловсруулсны 8.0 сая төгрөг, техникийн хяналтын зардлаас 62.2 сая төгрөг, үйл ажиллагаанаас 5.2 сая төгрөг зэрэг нийт 94.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 16.4 хувиар тасалсан байгаа нь орлогоороо зарлагаа нөхөж чадахгүй байдалд хүргэжээ.

2.2.Орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс зарлагаа нөхөж ажиллаж чадахгүйд хүрсэн байна.

2.2.1. 2015 онд нийт 113.2 сая төгрөгийн зарлага гарган ажиллах төлөвлөгөөтэйгээс 106.1 сая төгрөгийн зарлага гарган ажилласан байна. Нийт зардлын 70.7 хувийг цалин хөлс, 4.6 хувийг шатахуун, 3.1 хувийг байрны түрээс, 1.7 хувийг албан томилолт, 12.3 хувийг урсгал засварын зардал, 7.6 хувийг бараа үйлчилгээний зардал эзэлж байна.

2.2.2. 2016 оны эхний улирлын байдлаар 23.4 сая төгрөгийн зарлага гарган ажиллаж 1.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

2.2.3. Холбогдох хууль тогтоомжийг судлаагүй, хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавиагүйгээс хоолны хөнгөлөлтөнд олгосон 1925.0 мянган төгрөг, дарга Б.Равдандоржид олгосон үр дүнгийн урамшууллын 1877.0 мянган төгрөг, ажилтнуудын сул зогсолтын хөлс 1200.0 мянган төгрөг зэрэг нийт 5002.0 мянган төгрөгөөс татвар шимтгэл суутгаагүй, дарга Б.Равдандоржийн цалингийн урьдчилгаанаас 146.1 мянган төгрөгийг дутуу суутгасан байна.

2.2.4. Орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн, авлагаа бүрэн цуглуулж чадахгүй байгаагаас жилийн эцэст инженерүүд хийх ажилгүй болж, цаашид цалин хөлс олгох, урсгал зардлыг санхүүжүүлэхэд хүндрэл учирсан байна. Тухайлбал 2015 оны эцэст 4 сарын хугацаагаар сул зогсолтын хөлсөнд 1.2 сая төгрөг олгосноос гадна иргэн Д.Шинэбаяраас сарын 1.9 хувийн хүүтэй 6.0 сая төгрөгийн зээл авч цалин хөлс олгосон байна.

2.2.5. Тус үйлдвэрийн газар нь өнөөгийн байдлаар нийт 10 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үндсэн 6 хяналтын инженерээс гадна дарга, нягтлан бодогч, дотоод ажил хариуцсан ажилтан- нярав, бичиг хэргийн ажилтан тус бүр нэг ажиллаж байна. Дээрх байдлаас харахад 10 орон тоотой, ажлын ачаалал бага үйлдвэрийн газарт нэг чиглэлийн ажил эрхлэх дотоод ажил хариуцсан ажилтан, бичиг хэрэг хариуцсан ажилтан гэсэн 2 тусдаа орон тоо болон бие даасан нягтлан бодогч ажиллаж байгаа нь цалингийн үр ашиггүй зардлыг нэмэгдүүлж, ажилтнуудын цалинг төлж чадахгүйд хүргэж байна.

2.2.6 Иймээс орлого хомсдсон өнөөгийн нөхцөл болон ажлын ачааллыг харгалзан үйлдвэрийн газрын орон тоог цөөлөх, тухайлбал дотоод ажил, бичиг хэрэг гэсэн 2 тусдаа орон тоог нэгтгэж 1 хүн ажиллуулах, нягтлан бодогчийг бусад байгууллагын нягтлан бодогчид хавсаргах замаар цалингийн зардлыг хэмнэх нь зүйтэй юм.

2.2.7 Засгийн газрын 2012 оны 78 дугаар тогтоолыг баримтлан төрийн үйлчилгээний албан хаагчтай дүйцүүлэн ажилтнуудын цалинг тогтоосон гэх боловч үндсэн үүрэг гүйцэтгэж буй хяналтын инженерүүдийн сарын үндсэн цалинг 450,0-550,0 мянган төгрөгөөр тооцсон байхад туслах үүрэг гүйцэтгэж буй дотоод ажил хариуцсан ажилтны үндсэн цалинг 620,0 мянган төгрөгөөр, бичиг хэрэг-няравын цалинг 540,0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТҮ-гийн сүлжээний цалин, ажлын ачаалалтай нийцэхгүй байгаа бөгөөд цалинг үндэслэлгүй тогтоосон гэж үзэж байна.

2.3. Авлага, өглөгийг барагдуулах ажил үр дүнтэй байгаа боловч удирдлагын буруу шийдвэр, нягтлан бодох бүртгэлийн бичилтийн алдаа алдагдлын хэмжээнд нөлөөлсөн байна.

2.3.1. 2015 оны эхэнд 25 байгууллагаас 32.1 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан ба 26.0 сая төгрөгийн авлага шинээр үүсч нийт 33.3 сая төгрөгийн авлагыг барагдуулсан нь оны эхэнд байсан авлагын 98.8 хувийг, шинээр үүссэн авлагын 6.1 хувийг эзэлж байна.

2.3.2. 2015 оны эхэнд 14.3 сая төгрөгийн өглөгтэй байсан бол тайлант онд 115.5 сая төгрөгийн өглөг шинээр нэмэгдэж нийт 124.6 сая төгрөгийн өр төлсөн нь оны эхний өглөгийн 79.0 хувь, шинээр үүссэн өглөгийн 98.1 хувийг барагдуулсан байна. Авлага өглөгийн барагдуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6

	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Авлага	32.1	26.0	33.3	24.8
Өглөг	14.3	115.5	124.6	5.1

2.3.3. Нягтлан бодох бүртгэлийн бичилтийн алдаанаас үндэслэлгүй өглөг үүсгэж бүртгэл тайланд тусгасан байна. Тухайлбал, 2015 онд урамшуулал олгоно гэх үндэслэлээр 2014 оны санхүүгийн тайланд дотоод ажил хариуцсан ажилтан Мөнхжаргалын нэрээр 1,6 сая төгрөгийн өглөг үүсгэж тайлагнасан боловч 2015 он байтугай 2016 оны эхний улиралд ч урамшуулал олгоогүй учир уг өглөг тайлагнагдсаар байна.

2.3.4. 2016 оны эхний улиралд урьд оны авлагаас 11.9 сая төгрөгийг, өглөгөөс 3.4 сая төгрөгийг барагдуулсан байна

Бүлэг 3. Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу.

3.1. Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд явагдаж байна.

3.1.1. Тайлант 2015 онд тус үйлдвэрийн газар нь Санхүүгийн тооцоолох групп ХХК-иас 770.0 мянган төгрөгөөр санхүүгийн программ, Мишээл Экспо төвөөс ширээ сандал 995.0 мянган төгрөгөөр, МТЧ ХХК-иас 5767.3 мянган төгрөгийн шатахуун тосолгооны материал худалдан авч нэхэмжлэлийн дагуу төлбөрийг гүйцэтгэжээ.

3.1.2. Худалдан авсан үндсэн болон бараа материалыг орлогоор бүртгэж тооллого тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж ирсэн байна.

Дөрөв. Илрүүлсэн зөрчил

Аудитын явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Албан шаардлага:

- Б.Равдандоржоос 2015 онд олгосон цалингийн урьдчилгааг суутгаагүй 146.1 мянган төгрөг,
- Хөрөнгө оруулалтаар хийх ажлуудын зураг төсвийг гэрээгээр хийж гүйцэтгүүлсэн 8020.9 мянган төгрөг,
- Ажилтнуудад олгосон үр дүнгийн урамшуулал, сул зогсолтын хөлс, хоолны хөнгөлөлтөөс 950.4 мянган төгрөгийн татвар, НД-ын шимтгэл суутгаагүй зэрэг нийт 9117.4 мянган төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

Тав. Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь барилгын ажлын үе шат бүрд техникийн хяналтыг хэрэгжүүлснээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар сайжирсан байна.
- Гэвч тус үйлдвэрийн газар нь орлогоороо зарлагаа нөхөж, өөрөө өөрийгөө санхүүжүүлж ажиллах нөхцөл боломжгүй, өөрөөр хэлбэл ОНӨААТҮГ-ын хэлбэрээр ажиллаж чадахгүй байна.
- “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулагч аймгийн ИТХ болон аймгийн Засаг даргын зүгээс үйл ажиллагаанд нь хяналт тавьж, үр дүнг бодитоор үнэлээгүй байна.
- Орлогын төлөвлөлтийг үндэслэл муутай хийж байна.
- Үйлдвэрийн газрын бүтэц орон тоо, ажилтнуудын үндсэн цалинг үндэслэлгүй тогтоосон байна.

- Үйлдвэрийн газрын удирдлага, зохион байгуулалт, менежментийг сайжруулж, өөрөө өөрийгөө бүрэн санхүүжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.
- Захиалагчийн техникийн хяналтын гэрээг хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэгч компанитай байгуулж, санхүүжилтийг гүйцэтгэгч компаниар дамжуулан олгож байгаа нь хяналт бүрэн хэрэгжихгүй байх, улмаар төсөл, арга хэмжээ чанаргүй гүйцэтгэгдэх нөхцлийг бүрдүүлж байна.
- Зураг төсвийг захиалагчийг төлөөлөн бусдаар гүйцэтгүүлж байгаа нь үйлдвэрийн газрын дүрмийн холбогдох заалтыг зөрчиж байна.

Зургаа.Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт

- “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг үнэлэх.
- Орлогоороо зарлагаа нөхөж ажиллах нөхцөл боломж бий эсэх, уг үйлдвэрийн газар зайлшгүй оршин тогтнох шаардлагатай эсэхийг нарийвчлан судалж, шийдвэр гаргах.
- Зайлшгүй оршин тогтнох шаардлагатай бол удирдлага, зохион байгуулалт, менежментийн өөрчлөлт хийж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх нөхцлийг бүрдүүлэх.
- Тус үйлдвэрийн газрын орон тоог бодит байдалд үндэслэн цөөлөх, тухайлбал дотоод ажил, бичиг хэрэг гэсэн 2 тусдаа орон тоог нэгтгэх, нягтлан бодогчийг бусад байгууллагатай хавсран гүйцэтгүүлэх замаар цалингийн зардлыг хэмнэх.
- Ажилтнуудын үндсэн цалинг ажлын ачааллыг харгалзан, ТҮ-ний сүлжээнд дүйцүүлэн шинэчлэн тогтоох.

Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-ын захиралд

- Цаашид ашигтай ажиллах, бие даан оршин тогтнох боломжийг судалж хэрэгжүүлэх.
- Орлогыг бодит байдалд үндэслэн үнэн зөв төлөвлөх.
- Мэргэшсэн ажилтнуудыг тогтвор, суурьшилтай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн ажилтныг чадваржуулах
- Үүссэн авлага, өглөгийг барагдуулах
- Хяналтын гэрээг гүйцэтгэгч компанитай бус, захиалагчтай байгуулж, санхүүжилтийг өөрийн дансанд шууд шилжүүлүүлэх.
- Зураг, төсөв гүйцэтгэх ажилд үйлдвэрийн газрын дүрмийн холбогдох заалтыг баримтлах.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ч.ЭНХТУЯА
АУДИТЫН МЕНЕЖЕР	Б.БАТМӨНХ
АХЛАХ АУДИТОР	Б.НАРАНЧИМЭГ

2.2.